



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/32

Мандалтовь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр (Их тойруу-8-822 тоот)-т байршилтай иргэн Баяржаргал овогтой Энхбат (ЗЮ:86091612)-ын үйлчилгээний зориулалттай 500 м.кв (0,05га) газрыг иргэн Ханддорж овогтой Доржбямба (ЗП:92061311)-д зориулалтаар нь шилжүүлж 12 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн А/325 дугаар захирамжийн иргэн Б.Энхбат-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000712069 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213058